



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/276

Мөрөн


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29-р зүйлийн 29.1.6 “г” дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Засгийн газрын 2008 оны 109-р тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239-р тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайд аймагт ажилласантай холбогдон гарсан 8166431 төгрөгийн зардал, “Иргэндээ ээлтэй аймаг” сэтгүүлийг хэвлүүлэх зардалд 9400.000 төгрөг, “Аймгийн бүтээлч ажлууд” товхимол хэвлүүлэхэд 5000000 төгрөг, Бөхийн босоо цагаан хийморь номын үнэ 4800000 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үйлчилгээ авах боломжоор хангах, Инчоны стратегийг хэрэгжүүлэхэд 5000000 төгрөгийн зардал, Мөрөн сумын иргэн П.Энхтуяа, Н.Төмөрхуяг, Д.Цэрэндолгор нарт тус бүр 100000 төгрөг зэргийг зарцуулсугай.

2. Шаардагдах 32666431 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт зөвшөөрсүгэй

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР